

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-14</i>
1. Байнгын хорооны даргыг сонгох тухай	3-14

***Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 65.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 02 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Баясгалан, Х.Булгантуяа, М.Нарантуяа-Нара, Э.Одбаяр, Л.Энх-Амгалан.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд нар оролцов.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга П.Ганзориг оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Хэлэлцэж буй асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар үг хэлэв.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга П.Ганзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Нийгмийн бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, С.Эрдэнэбат, Ж.Чинбүрэн, С.Зулпхар, Ж.Баярмаа, Д.Үүрийнтуяа, Т.Доржханд, Б.Бейсен нар үг хэлэв.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Лутаагийн Энхнасанг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7

Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Б.Түвшин, С.Зулпхар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 40 минут үргэлжилж, 23 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 78.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
14 цаг 02 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 24 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя.

Ариунзаяа гишүүн ирсэн. Баярмаа гишүүн ирсэн. Бейсен гишүүн ирсэн. Болормаа гишүүн ирсэн. Ганхүлэг гишүүн ирсэн. Зулпхар гишүүн ирсэн байна. Мөнхсайхан гишүүн ирсэн. Идэрбат гишүүн ирсэн. Мөнхтуяа гишүүн ирсэн. Үүрийнтуяа гишүүн ирсэн. Саранчулуун гишүүн ирсэн. Сарнай гишүүн ирсэн. Чинбүрэн гишүүн ирсэн. Энхнасан гишүүн ирсэн. Эрдэнэбат гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Байнгын хорооны даргыг сонгох тухай.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалд оръё. Хэлэлцэх асуудал.

Байнгын хорооны дарга сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25.6-д Байнгын хороог Улсын Их Хурлаас нэг жилийн хугацаагаар сонгосон дарга тэргүүлнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.1-д Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ гэж заасан байгаа.

Улсын Их Хурлын гишүүн, МАН-ын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар таныг микрофонд урьж байна.

Л.Мөнхбаатар: Эрхэм гишүүдийн амрыг эрье. 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал бүтцээ байгуулж байна.

Ингээд энэ бүтцээ байгуулахдаа ард иргэдийн өгсөн санал, намуудын авсан суудлын тоог бас харгалзан үзэж, Улсын Их Хурлын бүтцийн байгууллагуудынхаа удирдлагыг томилох нь зүйтэй гэж Улсын Их Хурлын удирдлагын зүгээс үзсэн байгаа. Энэ хүрээндээ Нийгмийн бодлогын байнгын хороо дээр ХҮН намаас төлөөллийг нь удирдлагаар нь тавихаар зөвшилцөж ойлголцсон.

Тийм учраас ХҮН намаас нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийг дэмжиж өгөхийг эрхэм гишүүдээсээ хүсье.

Б.Бейсен: ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга Пүрэвжавын Ганзориг танилцуулна.

П.Ганзориг: Байнгын хорооны эрхэм гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Нийгмийн бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшиж буй Улсын Их Хурлын гишүүн Лутаа овогтой Энхнасангийн товч танилцуулгыг хийе.

Лутаагийн Энхнасан нь 1972 онд Улаанбаатар хотод төрсөн. Боловсрол

1980-аас 90 онд Улаанбаатар хот дахь Зөвлөлтийн 3 дугаар сургуулийг төгссөн. 1994-өөс 96 онд Япон улсын Сундай коллежид Аялал жуулчлалын менежментээр бакалавр, 2005-2007 онд Австрали улсын Монаши Их сургуульд Олон улсын аялал жуулчлалын магистр, 2010-2012 онд СЭЗДС-ийг Бизнесийн удирдлагын бакалавраар төгссөн. Англи, Орос хэлтэй.

Ажлын туршлагын хувьд 1990-ээс 93 онд Японы Иточу корпорацийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар нарийн бичгийн дарга, 2000-2004 онд Дэд бүтцийн яаманд Зам тээвэр, мэдээлэл холбоо, аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газарт мэргэжилтэн, 2004-2005, 2007-2009 онд Зам тээвэр, аялал жуулчлалын яаманд Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар мэргэжилтэн, орлогч дарга, 2009-2010 онд Байгаль орчны яаманд Аялал жуулчлалын газар орлогч дарга, 2010 оноос 2024 онд Тахь ко компанийн захирлаар ажилласан.

Мөн 2016 оноос одоог хүртэл Лодойдамба сангийн гүйцэтгэх захирал, 2020 оноос МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн.

Ингээд Байнгын хорооны эрхэм гишүүд та бүхнийг Байнгын хорооны даргад нэр дэвшигч Лутаа овогтой Энхнасанг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Б.Бейсен: Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлаар өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны дарга сонгох тухай асуудлаар асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүнд микрофон өгье.

С.Зулпхар: Баярлалаа. Байнгын хорооны хуралдаан даргалагч, Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Би нэр дэвшигчээс дараах зүйлийг бас тодруулмаар байна.

Нийгмийн хамгааллын бодлого зохицуулалтын чиглэлээр, хөдөлмөр эрхлэлтийн бодлого зохицуулалтын чиглэлээр, хүн амын бүлгүүдийн хөгжил, нийгмийн хамгааллын чиглэлээр голлох асуудлыг хариуцдаг ийм Нийгмийн бодлогын байнгын хороо юм байгаа юм.

Тэгэхээр энэ чиглэлээр өөрийн чинь ер нь туршлага хэр байгаа вэ? Үүнийг ер нь та бас хийж байсан ажил, магадгүй өөрийн чинь судалгаа байдаг юм уу? Оролцож байсан зүйл, улс төрийн бодлогын бас чиглэл ч юм уу энэ талаар бидэнд бас тодорхой мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна.

Б.Бейсен: Хариулъя. Лутаагийн Энхнасанд микрофон өгье.

Л.Энхнасан: Гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Би түрүүн танилцуулсны дагуу төрийн албанд 10-аад жил ажилласан. Мэргэжилтнээс орлогч дарга хүртэл ажилласан байгаа.

Нийгмийн бодлогын талаар би өөрөө Лодойдамба сангийн гүйцэтгэх захирлаар 10-аад жил ажиллаж байгаа. Мөн саяхан хамтран ажиллах санамж бичигт энэ хүүхэд хамгаалал, хөгжлийн лобби бүлэгт сая орсон. “Лантуун дохио”-той хамтарч ажилладаг. Ид шидийн орон, мөн мажик бокс гээд багийн гишүүн байгаа. Энэ багийн гишүүний хувьд энэ хүүхэд хамгааллын хууль дээр анхаарч ажиллана гэж төлөвлөж байгаа.

Б.Бейсен: Зулпхар гишүүн тодруулъя гэж байна.

С.Зулхар: Нэр дэвшигчид баярлалаа. Үгүй ээ, яах вэ, мэдээж хэрэг Улсын Их Хурлын гишүүн аль ч Байнгын хороонд орж ажиллаж болох ийм эрхтэй. ХҮН нам маань ч гэсэн бас энэ чиглэлээр зүүний чиг баримжаатай, нийгмийн сайн сайхны төлөөх үзэл баримтлалтай нам учраас энэ чиглэлээр бас энэ Байнгын хороонд орж даргалах ийм бодолтой байгаад бас сайшаалтай байна. Бас нэг талдаа зөв л байх гэж бодож байна. Гэхдээ яах вэ, нөгөө ажил хариуцна гэдэг чинь бас ажлыг маш сайн мэдэж байж эхлүүлэхгүй бол энэ парламент чинь анхны чуулган нь эхэлчихсэн.

Тэгээд одоо бид чинь гол гол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг хэлэлцэнэ. Тэгээд ингээд ажлууд явагдана л даа.

Тийм учраас яах вэ, миний зүгээр асуугаад байгаа юм тодорхой зүйл. Та хүүхэд хамгааллын хууль батлагдчихсан гэдгийг мэдэж байгаа, тийм ээ. Бид эхнээс нь хэрэгжүүлээд эхлэх гээд бэлтгэл хангаж байна.

Миний гол ярих гээд асуугаад байгаа зүйл бол одоо Нийгмийн даатгалын багц хууль маань бас хэрэгжээд явж байгаа. Энэтэй холбоотой бас дараагийн бас нэг хууль байгаа. Халамжийн хууль байгаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль байгаа гээд ингээд их тийм чухал ач холбогдолтой хуулиуд байгаад байна л даа. Энэ чиглэлээр хэр туршлагатай байна гэдгийг бас бие биедээ эхнээс нь асуугаад илэн далангүй бас ярилцаад явж байвал зөв байх гэж бодож байна. Яг энэ дээр таны байр суурийг сонсьё.

Б.Бейсен: Энхнасан гишүүн хариулъя.

Л.Энхнасан: Нийгмийн даатгалын ерөнхий багц хуулиуд сая 4 хууль батлагдсаныг мэдэж байгаа. Тэгээд энэ дээр яг өөрийн мэргэжлийн туршлага байхгүй. Тэгэхдээ нам, намын энэ

Байнгын хороод бол төлөөлөл байгаа учраас мэргэжлийн багийг ажлын хэсэг бүрдүүлээд ажиллах төлөвлөгөөтэй байгаа.

Ер нь өнгөрсөн энэ хугацаанд энэ Нийгмийн бодлогын байнгын хороо бол гол гол реформын хуулиудыг батлуулсан байгаа.

Тэгээд энэ хэрэгжилтэд нь илүү анхаарна. Ялангуяа орон нутгаар явахад иргэд энэ хуулийн талаар ойлголтгүй байна лээ. Тэгэхээр илүү хэрэгжилтэд нь илүү анхаарч ажиллах болно.

Мөн түрүүн нөгөө нэг асуулт дээр бас нэг нэмээд хэлэхэд би өөрөө Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн танхимын гишүүн. Тэгээд энд бас нэг хууль бас яригдаж байсан. Энэ болохоор Эмэгтэйчүүдийн бизнесийн эдийн засгийн оролцооны хууль байгаа. Энэ хууль дээр бас анхаарч ажиллах болно.

Б.Бейсен: Эрдэнэбат гишүүнд микрофоноо шилжүүлъя.

С.Эрдэнэбат: Нийгмийн бодлогын байнгын хороо өөрөө маш олон функцтэй. Энд ганцхан хүүхэд хамгааллын асуудал байдаггүй. Нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадууд шууд болон шууд бусаараа боловсрол хийгээд энэ нийгмийн суурь маш олон сегментийн ашиг сонирхлыг хангаж байдаг ийм салбар юм байгаа юм.

Тэгэхээр 1 талаасаа яах вэ, танхим ажил олгогч талаараа илүү их ажилласан юм байна. Нөгөө талд энд чинь нийгмийн хамгаалал гэдэг утгаараа, нийгмийн бодлого гэдэг утгаараа жирийн ажилчид, нөгөө талаараа нийгмийн сонирхогч бүлгүүдийн тэр эрх ашгийн тэмцлийг хэрхэн хангах вэ? ХҮН нам яах вэ, сая юу хэлсэн, либерал нам буюу барууны чиглэлтэй нам л гэдэг утгаараа яваад байх уу?

Тийм учраас энэ тал дээрээ магадгүй өөрийн чинь туршлага яг энэ тал дээр цөөхөн байх шиг байна.

Тэгэхээр нийгмийн тэнцвэрийг хангах, нийгмийн хамгааллын бодлогууд дээр маш сайн өмнөх хийж байсан энэ залгамж халаа, бодлогуудыг үргэлжлүүлэх, сайжруулах, засах гэдэг энэ тал дээр яг ямар ажлууд өөрт чинь бодогдож байна вэ?

Б.Бейсен: Энхнасан гишүүн хариулья.

Л.Энхнасан: Нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамжийн багц хуулиуд нь батлагдсан. Нийгмийн энэ шинэчилсэн хуулиуд батлагдсантай холбоотой хуулийн шинэ орчин, хуулийн хэрэгжилт, иргэд олон нийт багц хуулиуд талаар Эрдэнэбат даргын хэлж байгаагаар би бүрэн дүүрэн одоогоор ойлголт байхгүй. Гэвч ХҮН намд мэргэжлийн баг байгаа. Энэ мэргэжлийн багаа ажиллуулахдаа энд зөвхөн энэ Байнгын хороод хамаарагдаж байгаа биш мөн мэргэжлийн хүмүүсийг оролцуулж, ажлын хэсэг байгуулж ажиллана гэдэгтээ амлая.

Б.Бейсен: Асуулт асууж дууслаа.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Баатархүү гишүүнд асуулт асууя, үг хэлье.

Ц.Баатархүү: Байнгын хорооны даргад юуны түрүүнд бас амжилт хүсэж байна. Байнгын хорооныхоо гишүүдэд бас амжилт хүсэж байна. Бид нарын өнөөдрийн эхний хуралдаан.

Тэгээд хорооны хамрах хүрээ өөрөө нийгмийн маш олон талбарыг уялдуулах ийм шаардлага байдаг. Тэгээд үүнийхээ бас гүйцэтгэлийг үнэлэхэд өөрөө бас их харьцангуй байдаг. Нийгмийн салбарын бодит гүйцэтгэлийг.

Эдийн засгийн салбарын гүйцэтгэлийг үнэлэхэд тоогоор ки пи ай байдаг юм уу гүйцэтгэлийн менежментээр гаргаад байдаг.

Тэгээд энэ нийгмийн салбар яг бодит үр дүн яаж гарч байгаа юм бэ гэдэг бол харьцангуй ийм үр дүнтэй байдаг учраас маш сайн хичээж ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Би ингээд ХҮН намаас зөвшилцлийн дагуу Байнгын хорооны дарга сонгогдож байна гэж ойлгож байгаа. Доржханд гишүүн маань бас дасгалжуулаад хажууд нь сууж байна гэж ойлгож байгаа.

Тэгээд би бас Доржханд гишүүн өнгөрсөн парламентад байхдаа Хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийн төсөл өргөн барьж байсан шиг санаж байна. Би буруу санаагүй бол.

Тэгэхээр энэ нийгмийн даатгалын салбар энэ суурь тогтолцоо өөрөө өрнөөс өрний хооронд явж байгаа. Энэ Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо өрнөөс өрний хооронд явж байгаа. Тэгээд үүнийг сууриар нь шинэчлэх зоригтой шинэчлэх энэ ажлыг бас манай Байнгын хороо дээр орж ирж асуудлыг шийдүүлээсэй гэж би бодож байна. Шинэ даргад бол. Энэ маш том суурь шинэчлэлийн асуудал байх болно гэж бодож байна.

Ер нь энэ хувийн хэвшлийн оролцоог оролцуулсан энэ даатгалын чиглэлээр ажилладаг, энэ даатгалын салбарынхныг энэ зөвхөн энэ банк санхүүгийн салбар гэж үзэлгүй иргэдийн өмнө байгаа нийгмийн асуудлыг шийддэг учраас энэ даатгалын салбарынхныг энэ үйл ажиллагаанд идэвхтэй төр, хувийн хэвшлийн түншлэлээр авч явах нь зөв өө гэдэг ийм саналтай байгаа.

2 дахь нэг товчхон санал байгаа. Ер нь энэ Монгол Улсыг хүүхдэд ээлтэй улс болгох, энэ индексийг урагшлуулах чиглэл дээр бид нар санаачилга гаргах

хэрэгтэй. Дэлхийн улс орнуудын хөгжлийн бодлогын толь бол хотууд өөрөө хүүхдэд ээлтэй байх тухай асуудал яригдаж байгаа.

Тэгээд би зүгээр хувь гишүүнийхээ хувьд бодож явдаг юм. Энэ Улсын Их Хурлын гишүүд нь ч тэр, нийслэлийн иргэдийн хурал нь ч тэр, дүүрэг ч тэр баахан хүүхдийн тоглоомын талбай барьж өгөөд ингээд хүүхдэд ээлтэй болчихлоо гэж эндүүрээд байдаг. Ийм цогц бодлого байхгүй.

Ер нь Монгол Улс 1990 оноос хойш 1 ч хүүхдийн байгууламж нэмээгүй юм байна лээ. Ер нь шулуухан хэлэхэд энэ хүүхдийн номын ордныг ХХБ бариад л том байшин босгочихсон. Тэгэхээр бид нар энэ Сүхбаатар, ЧД-ээс сонгогдсон Болормаа гишүүн бид 2 энэ Монгол Улсад энэ хүүхдийн хөгжлийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр том бүтээн байгуулалтын ажлуудыг оруулж ирнэ.

Өнөөдөр Монголын хүүхдийн оронд Улаанбаатар хотын хүүхдүүдийн нэг хувь хамрагддаг юм. Бусад нь хамрагдах гээд хөөрхий хоцордог юм. Одоо энэ та нар мэдэж байгаа бүгдээрээ л эцэг эхчүүд утасдаж байна. Найрамдал зусланд Монгол хүүхдүүд амарья гээд байдаг. Тэгэхээр энэ хүүхдийн чиглэлээр маш том инновацлаг бүтээн байгуулалтын ажлуудыг энэ 4 жилд хийх ёстой шүү.

Тэгээд энэ засаг төр нь ч гэсэн хамтарч байгаа юм байна. Энэ дээр Байнгын хорооны гишүүд дэмжээрэй. Бид нар бас тодорхой саналуудыг оруулж ирнэ ээ гэдгээ хэлье. Тэгээд бүгдэд нь амжилт хүсье. Баярлалаа.

Б.Бейсен: Чинбүрэн гишүүн. Эрдэнэбат гишүүн байгаа юм байна.

С.Эрдэнэбат: 1 дүгээрт, хүний хөгжлийн асуудал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал маш чухал байгаа. Бид нар

үүнийгээ бас маш сайн өргөн утгаар нь харах ёстой. Ажлын байр бий болгоно гэхээр бид нар тооны араас бас явах гээд байдаг, чанарын асуудалд анхаардаггүй. Олон улсын байгууллагуудын өгч байгаа мессеж бол ойрын хугацаанд хөдөлмөрийн энэ зах зээл дээр маш олон савлагаанууд гарна. Хөдөлмөр эрхлэлтийн шинж байдал өөр өөр болсон.

Тийм учраас бид нар энэ хөдөлмөр эрхлэлт гэдэг зүйлийг шинээр ажлын байр бий болгохоос гадна хэр зэрэг чанартай, тогтвортой, хүртээмжтэй ажлын байр вэ гэж, 1.

2 дугаарт, энэ хөдөлмөр эрхлэлт нийгмийн бодлогуудыг барих нэг хөшүүрэг байгаад байгаа юм. Тухайлбал барууны орнууд, дэлхийн, Европ энэ бусад орнууд юу харж байна вэ гэхээр энэ төсөв, санхүү, хөрөнгийн бодлогуудтай уяж өгөх ёстой байгаа. Манай банк санхүүгийн байгууллагууд хүртэл зээл олгохдоо төсвөөс орж, хүртээмж тендер тусламж авахдаа хүртэл түүн дээр нь нийгмийн үнэлгээ гэдэг зүйлийг хийдэг болсон байна лээ. Энэ тендерийг авснаараа хэчнээн ажлын байр бий болгох юм, жижиг, дунд олон бизнесүүдийг яаж дагуулах юм гэдэг энэ асуудал байгаа юм. Тэгэхээр энэ асуудал ерөөсөө орхичих гээд байдаг ийм асуудал байгаа.

3 дугаарт, нь эрүүл мэндийн асуудал бас ингээд нэлээн шилжилтийнхээ үед яваа. Энэ тал дээр бас манай Байнгын хорооныхон ер нь маш сайн очиж ажиллах, шаардлагатай шийдвэрүүдийг нь гаргаж өгөхөд бас шаардлага байгаа. Нэлээн том алхмууд хийгдчихсэн. Энэ тал дээр бас нэлээн анхаарч ажиллах шаардлага бий.

Тийм учраас өөрийн чинь түрүүн хэлдэг шиг зөвхөн манай намын мэргэжлийн баг байгаа гэдэг талаас нь харж болохгүй. Энэ зөвшилцлийн Засгийн газар бараг бүрдэх юм шиг байна. Тийм учраас бүх намуудад байгаа,

бүх туршлагатай, мэдлэгтэй хүмүүсээ дайчилж ажиллаарай. Яамны сайдыг дагаад явдаг Байнгын хороо байж болохгүй. Тэр яамыг өөрөө удирдах, чиглүүлэх, хамааралтай хүмүүсийг татан оролцуулах ийм бас зангаргатай дарга байх ийм шаардлага байдаг. Байнгын хороод дээр. Тэр тал дээр нь анхаарч ажиллах ёстой.

Тэгээд нийгмийн түншлэлийн асуудал дээр маш их анхаарал хандуулаарай. Бид нар Их Хурал бүрдлээ. Нэг удаа сонгогдлоо. Түүнээсээ цаашаа бусад нийгмийн оролцогч талуудынхаа дуу хоолой, үг, үйлдлийг маш сайн бид нар авч чадах юм бол, тэднийхээ дэмжлэгийг авч чадах юм бол бид нар энэ 4 жилийн хугацаанд маш олон зүйлийг амжуулна. Нийгмийн бодлогын байнгын хороо маань өөрөө нэр хүндтэй, илүү чухал хууль тогтоомжуудыг гаргаж өгөх ийм боломж бололцоо байгаа.

Тэгээд даатгалын асуудал бол өөрөө маш суурь асуудал. Нийгмийн даатгалын багц хуулийг бид нар өнгөрсөн 4 жилд маш том алхаж чадсан. Гэхдээ дутуу орхичихсон жижиг сажиг зүйлүүд байгаа. Дагаад маш олон журмууд хүлээгдэж байгаа. Тэр нь өөрөө хүний аж амьдралтай холбоотой маш чухал зүйлүүд байгаа учраас энэ талууд дээрээ бид нар нийгмээ, иргэдийн амьдралаа имэрч мэдэрч тэр шийдвэрүүд дээр бид нар хуулийн анхны төслүүд дээр хамгийн их сайн ажиллах нь энэ Байнгын хороод байгаа учраас энэ тал дээр бид нар маш сайн анхаарах хэрэгтэй болов уу гэж харж байна.

Тэгээд хөдөлмөрийн асуудал гэдэг энэ зүйл дээр энэ яамны нэрээс авхуулаад бид нар анхаарал хандуулах ёстой юм байна. Хөдөлмөр гэдэг зүйлээ аваад хаячхаж болохгүй. Өөрөө маш нийгмийн бүх орнууд дээр суурь байдаг учраас Байнгын хорооны хэрвээ дарга болбол та энэ тал дээр маш их анхаараарай. Хэдүүлээ энэ тал дээр илүү их баг болоод ажиллах болов уу. Яах вэ, туршлага бага

байж болно. Гэхдээ хандлага зөв, эрч хүч өндөр, хүмүүсээ татан оролцуулах, нам, эвслээр нь ялгахгүй байх гэдэг юм уу энэ тал дээр анхаарч ажиллаарай. Тэгээд ард түмэн нэг л зүйлийг хүлээж байгаа. Энэ цалин хөлсний бодлого, нийгмийн хамгааллын бодлого, ийм зүйл дээр эд нар ямар ахиц гарах гэдэг зүйлийг хамгийн их хүлээдэг юм байна лээ.

Тэгээд энэ тал дээр хэдүүлээ санаачилгатай, тэгээд мэдээж залгамж чанартай ийм байдлаар ажиллахыг бас захиж хэлмээр байна. Тэгээд нийгмийн энэ хөгжлийн асуудал дээр бид нарт томоохон, бас урагштай, сайн зүйлийг нь урагшлуулаад, амжаагүй зүйлүүдээ нэлээн амжуулаад явах ийм чухал цаг нь хаана яваад байна.

Б.Бейсен: Чинбүрэн гишүүн. Цаг нь 4 минутаас хэтрэхгүй үг хэлэх ёстой юм байна. Энэ цаг гардаггүй юм байна шүү дээ, уг нь тасалчхаж байгаа юм. Хуучин юм болохоор чинь уг нь таслаад хаячихдаг минут нь болохоор тэгдэг байсан.

Ж.Чинбүрэн: Дарга нэр хэлэхгүй бол микрофон нээхгүй байна. Баярлалаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бүгдээрээ бас энд чухал Байнгын хороонд орж ирлээ. Нэр дэвшигчид бас сануулж хэлэхэд та бас их буруу яриад байна шүү. Энэ нэг намын ажил энд хийх гээгүй шүү. ХҮН намын баг орж ирээд энэ Нийгмийн бодлогын байнгын хороог явуулах гэж байгаа эд биш ээ. Энэ бол энэ Байнгын хороонд ажиллаж байгаа бүх гишүүдийн оролцоог ижил жигд ялгаагүй оролцуулах нь таны үүрэг байгаа юм. Тийм учраас үүнийг 1-д анхааруулчихъя.

2-т, мэдээж том асуудал байгаа. Бас 20-24 онд олон багц хуулиуд батлагдсан. Нийгмийн халамжийн, Хөдөлмөрийн хуулийн, Хөдөлмөр

эрхлэлтийн тухай хууль, эрүүл мэндийн салбарын маш олон олон хуулиуд.

Тэгэхээр бид бас нөгөө талаасаа хуулийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх чиглэлд бас ажлын хэсгүүд гаргаж ажиллах, мөн өмнө нь өргөн баригдсан хуулийн төслүүд байж байгаа. Ажлын хэсгийг гаргаж энэ хуулиудыг яаралтай батлуулах үйл ажиллагаа. Мэдээж даргын зөвлөл дээр та дуу хоолой чанга байх хэрэгтэй. Байнгын хороодын гишүүдээ төлөөлж тэнд суух учраас Байнгын хороодын үйл ажиллагааг хуваарьт оруулах чиглэлд илүү манлайлалтай ажиллах ёстой шүү.

Тэгээд мэдээж энэ манай Байнгын хороонд та бүхэн хар л даа. Олон сайдууд хийж байсан улсууд хүртэл байж байна. Нийгмийн бодлогын Ариунзаяа сайд өөрөө байж байна, дэд сайд нь байж байна. Эрүүл мэндийн сайд байсан хүн байж байна. Ингээд бодоход ер нь асар их том хүч байгаа.

Дээрээс нь шинээр нэмэгдэж орж ирж байгаа гишүүд маань дандаа энэ чиглэлийн асуудлыг энэ Байнгын хорооны чиглэлийн асуудалд анхаарал тавьж байгаа ийм гишүүд орж ирсэн байна.

Тийм учраас хэдүүлээ бас хамтарч, яаж Монгол Улсынхаа энэ нийгмийн асуудлыг илүү хамгийн хүнд асуудал шүү дээ энэ чинь. Ерөөсөө нийгмийн бодлого гэдэг маань өөрөө хамгийн хүнд асуудал. Олон асуудлууд ордог учраас үүнийг хэрэгжүүлэх ёстой.

Би төгсгөлд нь нэг эрүүл мэндтэй холбоотой хэдэн зүйлүүдийг бас хэлчихье гэж бодож байна. Өнгөрсөн парламентын хугацаанд бас Засгийн газрын хэрэгжүүлж чадаагүй хууль байж байна. Эмнэлгийн тусламжийн тухай хууль одоог хүртэл хэрэг бүрэн хэрэгжиж чадаагүй явж байх жишээтэй. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо өрнөөс өр гэдэг үнэн. Гүйцэтгэлээр санхүүжүүлэх

маш том концепцын шинэчлэл хийсэн хэрнээ төсөв нь хүрдэггүй, эс үгүй бол хасах баланстай өр нь барагддаггүй. Тэгэхээр таны хийх ёстой ажил бол ерөөсөө л ажлын хэсэг гаргаад л бид нарын гол үүрэг бол энэ хууль батлах, төсөв батлах, түүнийгээ хянах. Ийм учраас энэ чиглэлдээ илүү гишүүдийнхээ гишүүдээ манлайлуулан оролцуулах нь таны гол ажил гэж харж байгаа.

Тэгээд ажилд нь бас сонгогдвол амжилт хүсье.

Б.Бейсен: Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Баярлалаа. Юуны өмнө Энхнасан гишүүнийг Байнгын хорооны даргаар болж байгааг дэмжиж байгаа. Бид парламентыг бүрдүүлсэн улс төрийн нам болон хүчнүүд Байнгын хороодод жигд орж ажиллах, түүнээс гадна бас даргалах нь зүйн хэрэг гэж ойлгож байгаа юм. Энэ бол засаглалын зохистой бас зохион байгуулалтын нэг байх гэж бодож байна.

Яах вэ, энэ салбарт бас тодорхой хугацаанд байсан туршлага бас мэдээлэлдээ тулгуурлаад бид бас танд цаашдаа яаж ажиллах вэ гэдэг зүйл саналаа л хэлж байгаа шүү. Өнөөдөр бид танд саналаа хэлнэ. Та үүнээс хойш бид нарыг даргална шүү дээ. Бид яах вэ, өнөөдөр саналаа хэлээд цаашдаа яаж ажиллах вэ гэдэг зохион байгуулалтаа л ярих байх.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн тухай хууль бэлэн болчихсон байгаа. Саадгүй бол Хүртээмжийн тухай хууль гээд жишээ нь хууль байж байгаа. Энэ 2 хуулийг бид энэ намрын чуулганаар яаралтай батлуулах шаардлагатай гэж ойлгож байгаа юм. Сая бид нар чуулганы нээлт дээр л манай Баясгалан гишүүнд ямаршуу жишээ нь хүртээмжийн бэрхшээл тохиолдож байгааг бүгдээрээ л харлаа шүү дээ. Тэгэхээр энэ өөрөө хуулиа гаргах дараа нь энэтэй холбоотой бид бодлогоо

хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх энэ томоохон эр зориг шаардсан бас хамтын ажиллагаа шаардсан ийм л процесс явж байх шиг байна гэж бодож байна. Энэ дээр хамтарч ажиллая. Хэдүүлээ даргынхаа өгсөн даалгаврын дагуу бүгд идэвхтэй оролцёе. Энд бас гишүүд маань бас энд тухайлан хариуцах гишүүд бас энэ дотор байгаа гэж бодож байна.

Дараа нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль байгаа юм. Энэ яах вэ, сая бол яам салгахгүйгээр нэг байлгасныг би их сайн боллоо гэж бодож байна, Доржханд гишүүн ээ. Яагаад гэвэл хэдүүлээ нэг юм цэгцэлчихсэн байгаа юм. Бид ингээд зовж зовж юм цэгцэлчихсэн юм. Халамж, хөдөлмөр 2-ыг энэ хооронд нь уялдуулчихсан. Одоо Ариунзаяа сайдын манлайлал доор гэж хэлж болно. Булгантуяа сайдын манлайлал доор, Сарангэрэл сайдын манлайлал доор.

Тэгээд бид үүнийг ахиад задлаагүй нь их сайн боллоо. Би задалчих болов уу гэж бас л болгоомжлоод байлаа л даа. Бид Монголд чинь нэг юм хийж байгаад тэгээд энэ задалж хаячхаад ахиад дараа нь өө болохоо байлаа гэдэг рүү л ордог ийм практик өнгөрсөн 30 жил явсан учраас энэ давтагдахгүй боллоо гэж бодож байна. Тэгэхдээ энэ дээр бид энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль байгаа юм. Бэлэн бас болчихсон. Үүнийг бас хэдүүлээ авч орьё. Энэ хөдөлмөр эрхлэлтийг л дэмжиж байж бид нар нөгөө улсуудынхаа нийгмийн хамгааллыг л хийнэ шүү дээ. Ер нь нийгмийн хамгааллын 3 аргын нэг бол халамж. Нэг нь даатгал, нөгөөх нь хөдөлмөрлөлт.

Тэгэхээр энэ үүднээс энэ дээр бас хууль бэлэн болсон шүү гэдгийг бас даргадаа дарга болох гэж байгаа нэр дэвшигчдээ хэлье.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль. Энэ нийгмийн даатгалын багц хууль бэлэн болоод хэрэгжээд эхэлж

байна. Бид баталчихсан, энэ хууль бол боломжийн сайн хууль. Түүнээс гадна би хүмүүст бас ер нь зориуд хэлмээр байна. Хэдүүлээ одоо байгаа өнгөрсөн хугацаанд ажилласан нийгмийн даатгалын тогтолцоо байна шүү дээ, маш муу байсан гэж ерөөсөө ярьж болохгүй. 8 жил судалгаа хийсэн, гаднын ижил төстэй пост коммунист орны бүх шинжээчид ирсэн, судалгаа хийсэн. Би 2 жил энэ судалгааны багт байлаа. Энэ бол боломжийн түвшинд ажилласан тогтолцоо. Одоо шинэ хуулиар боломжийн болж байгаа. Харин бид энэ дээр либералчлаад шинэ сонголтыг оруулж ирж байгаа энэ хуулиа л хурдан баталмаар байна. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг. Үүнийг баталчих юм бол нөгөө бидний хүсээд байсан зарим нэг жишээ нь нийгмийн салбарт либералчлалыг бий болгоно гэсэн бидний зорилт байгаа шүү дээ. Танай намын ч гэсэн зорилт яг тийм байгаа. Би түүнийг нөгөө хөтөлбөрийг нь уншсан учраас сайн санаж байна. Энэ дээр хэдүүлээ бас ингээд ажиллавал их тийм сайн үр дүн гарах байх гэж бодож байна.

Энхнасан нэр дэвшигчид нэг зүйл дээр санал нэг байна. Одоо хууль батлах бол нэг хэрэг. Баталсан хуулийн хэрэгжилтийг жишээ нь хангуулах дээр бид их тийм санаачилгатай ажиллана. Энэ дээр ер нь Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр, түүнээс гадна нийгмийн ... /минут дуусав/

Б.Бейсен: Саранчулуун гишүүн. Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Байнгын хороодын гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд Энхнасан гишүүнийг дэмжиж байна. Нэг талаасаа. Нөгөө талаасаа хувь хүнийх нь хувьд мэдлэг боловсрол бас төрийн албанд ажиллаж байсан туршлага, хэл ус, дэмжиж байна. Нөгөө талаасаа бас баруун төвийн үзэл баримтлал бүхий намаас бас энэ Нийгмийн бодлогын

байнгын хороог тэргүүлэх болсонд бас баяртай байна.

Тэгээд мэдээж төрийн алба залгамж халаа байлгүй яах вэ, түүнийг ойлгож байна. Мөн ямар ч Засгийн газар байсан нийгэмд хэрэгцээ шаардлагатай байгаа иргэдэд заавал ч үгүй тусламж хүргэх ёстой, халамжлах ёстой, тэд нарт үйлчилгээ үзүүлэх ёстой. Үүнийг бас ойлгож байна. Гэхдээ энэ дээр залгамжлаарай, байгаа хуулиудыг нь хэрэгжүүлээрэй гэхээс илүү бодлогын шинжтэй реформын шинжтэй юмнуудыг хараарай, хийгээрэй. Энэ дээр би 2 асуудлыг л хий хэлье л дээ. Нөгөө хавтгайрсан халамж гээд л бид ярьдаг. Үүнтэйгээ зууралдсаар л байгаа.

Тэгэхээр үүнийг тэр халамжийг хавтгайруулах энэ бодлогоос нь татгалзаж, эсрэгээрээ тэр зорилтот бүлэг рүү нь түлхүү яг шаардлагатай зүйлийг нь тултал нь үзүүлэх энэ чиглэл рүү бас асуудлыг хараарай гэж хэлмээр байна. Тэгэхгүй бол зорилтот бүлэгтээ очиж байгаа халамж үйлчилгээ нь маш бага буюу огт хүрэлцээгүй мөртөө ямар ч халамж шаардлагагүй хүмүүст асар ихээр төсвийн дарамт учруулж ингэж үйлчилгээ очдог байгааг анхаарах хэрэгтэй байх.

2 дугаарт, хөдөлмөрийн зах зээлийг либералчлах тал дээр бас бодож үзэх хэрэгтэй байх. Яагаад гэвэл үүнийг ер нь эрх баригч нам хийж чаддаггүй. Энэ бол хамгийн хэцүү асуудал. Яагаад гэвэл энэ чинь эргээд нөгөө сонгогчидтой холбоотой асуудал байдаг учраас маш зоригтой хүн, яг магадгүй энэ хамтарч байгаагаа ашиглаж хийх л нэг ийм чухал асуудал байгаа юм шүү. Тэгэхээр энэ хөдөлмөрийн зах зээлийг либералчлах асуудал дээр анхаараарай. Бодлогод нь реформын шинжтэй юм оруулаарай.

Дахиад хэлэхэд, энэ хавтгайрсан халамж буюу нөгөө 72 төрлийн 551 ширхэг халамж үйлчилгээ байгаагаас нийт иргэдийн бараг 76,4 хувь нь билүү

ямар нэгэн байдлаар хүртдэг гэдэг. Энэ дээр судалгааг маш сайн гаргах хэрэгтэй, тэр давхардлыг нь арилгах хэрэгтэй, шаардлагагүй хүнд очдогийг нь зогсох хэрэгтэй гэдэг дээр хатуу байр суурьтай байгаа учраас та бас энэ тал дээр анхаарч ажиллаарай гэж хүсье.

Б.Бейсен: Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороо бас их цар хүрээ, хамрах хүрээ, их өргөнтэй, шийдвэрлэх хэлэлцэх олон асуудалтай том Байнгын хороог та бас ахлахаар ХҮН намаас нэр дэвшиж орж ирж байна. Өнөөдөр тэгээд нам, улс төрийн хувьд бид бас зөвшилцлийн ширээний ард сууж өнөөдөр яг энэ Байнгын хороог ХҮН намаас төлөөллөө оруулж ирэхэд эмэгтэй хүний хувьд таныг хэдийгээр ажлын туршлага багатай ч гэсэн бас зориглоод ороод ирж байгаад талархалтай байна. Яг энэ Байнгын хорооны хувьд хүн ам зүйн бодлого, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт мөн мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал, жендерийн асуудал, эрүүл мэндийн бодлого гээд үндсэндээ нийгмийн зөөлөн дэд бүтэц рүү чиглэсэн энэ том бодлогын асуудлууд дээр хууль, эрх зүйн реформ шинэчлэлүүдийг хийх энэ зүйл дээр Байнгын хорооны чиг үүргийг маш сайн хэрэгжүүлэхэд та манлайлал үзүүлж, удирдаж ажиллах ийм чиг үүргийг хүлээхээр зорьж орж ирж байгаа байх гэж бодож байна.

Тийм учраас энэ талд илүү мэдрэмж, танаас эмэгтэй хүний мэдрэмж, нөгөө талдаа намынхаа хүчинд намынхаа баг хамт олонд найдахаас илүү энэ Байнгын хороонд ажиллаж байгаа гишүүдийн дадлага, туршлага энэ хүмүүсийн мэдлэг, боловсролд, энэ хүмүүсийнхээ хүчинд найдаж таныг бас энэ манлайллыг гаргаж ажиллах болов уу гэж би бодож байна. Өнөөдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, сайд, дэд сайд, мөн үйлдвэрчний эвлэлийн

холбооны ерөнхийлөгч байсан хүмүүс, Эрүүл мэндийн сайд байсан хүмүүс энэ Байнгын хороонд байна гэдэг бол танд асар том хүч намд чинь биш Байнгын хороонд байгаа шүү гэдгийг л би бас онцолж хэлэхийг хүсэж байна.

Нөгөө талдаа бид бас энэ аливаа хууль, эрх зүйн асуудлууд ер нь бүхий л батлагдаж байгаа хуулиуд дээр нийгмийн хамгааллын бодлогын мэдрэмжтэй байх энэ асуудлууд манай Байнгын хорооны бас анхаарах ёстой нэг асуудал гэж бодож байгаа юм. Тухайлах юм бол Худалдан авах ажиллагааны хууль гээд ярихаар энэ нийгмийн асуудлуудад хамааралгүй юм шиг ойлгогддог. Гэтэл яг энэ худалдан авах ажиллагааны хуулиар нөгөө хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай асуудал чинь энд давхар явж байдаг. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг ч гэсэн тусгаж оруулах боломжууд нь энд явж байдаг.

Тийм учраас энэ бусад хууль, эрх зүйн шийдвэрүүдийг гаргахад, хууль, эрх зүй батлагдахад тэр өөрөө нийгмийн хамгааллын бодлогын мэдрэмжтэй байгаа эсэх дээр та бас яг энэ зөвлөлд орж ажиллах хүний хувьд илүү мэдрэмжтэй хандаж, энэ дээр Байнгын хороогоо чиглүүлж, гишүүддээ бас үүрэг даалгавар өгч, тодорхой асуудлуудаар ажлын хэсэг гаргаж, бусад Байнгын хороодтойгоо их хамтын ажиллагаатай байх хэрэгтэй юм байна шүү гэдгийг л онцолж хэлэхийг хүсэж байна. Ингээд танд амжилт хүсье.

Б.Бейсен: Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Би нэг товчхон мэдээлэл өгсөн юм. Тэгэхээр Нийгмийн бодлогын байнгын хорооныхоо гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд ер нь өмнөх 4 жилийг ингээд анзаарч байхад хамгийн тийм идэвхтэй байдаг, хамгийн их олонд хүрдэг, тэгээд бас шулуухан хэлэхэд хамгийн том улс төрчид нь ингэж орж

ирдэг ийм Байнгын хороо байдаг. Яагаад вэ гэхээр нөгөө улс төр хийгээд нөгөө тойрог дээрээ иргэд ажиллалаа гэхэд тийм ээ, иргэдтэйгээ уулзлаа гэхэд хамгийн их асуудал яг Нийгмийн бодлогын байнгын хорооноос гарч ирдэг юм байна лээ л дээ. Тэгээд тийм болохоор энэ их тийм хариуцлагатай Байнгын хороо юм байна лээ. Тэгээд та бүгд бас яг энэ хариуцлагатай энэ том реформ бас хийгдчихсэн байгаа, цаашаа үргэлжлэл нь ингээд хийгдээд явах ёстой яг энэ цаг үед орж ирж байгаа болохоор бүгдэд нь бас амжилт хүсье.

Тэгээд 1 зүйлийг зүгээр тодруулаад хэлэх гэсэн юм. Сая нөгөө гаднаас орж ирээд манай нөгөө ХҮН нам дээр ийм баг байгаа, тэгээд тийм болохоор, үүгээрээ бас ажлын хэсэг болгоод ажиллах нь зүйтэй гэсэн байдлаар хийсэн. Тэгээд түүнийг манай гишүүд бас жаахан буруугаар ойлгочих шиг боллоо. Мэдээж энд төрийн бодлого шийдвэр эндээ л гарна. Тэгээд энд түрүүн бас Чинбүрэн гишүүн хэлж байх шиг байна. Сайд нар байсан тэгээд янз янзын л туршлагатай хүмүүс ингээд тал бүрээс орж ирсэн байна. Тэгээд тийм болохоор үүнийг үр дүн нь чухал шүү дээ. Тэгээд анх удаагаа нөгөө сонгогдсон гишүүн тухайлбал мэдээж эхний ээлжид жаахан туршлага хэрэгтэй байдаг. Тэгээд түүн дээр нь та бүгд бас дэмжээд өгөөрэй.

Тэгээд нөгөө талдаа мэдээж бүх хүмүүсийн оролцоог хангасан байдлаар манай ХҮН намын төлөөллүүд, ялангуяа Байнгын хороодын дарга нар ажиллах болно. Түүн дээр харин битгий эргэлзээрэй. Тэгээд та бүгдэд бүгдэд нь амжилт хүсье. Баярлалаа.

Б.Бейсен: Хуралдаан даргалагч би саналаа хэлчихье. Энэ Нийгмийн бодлогын байнгын хороо маш эмзэг бөгөөд хариуцлагатай чухал салбар. Энэ Байнгын хороон дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хийж байсан, дэд сайд хийж байсан, Эрүүл мэндийн сайд хийж байсан, дүүргийн Засаг дарга

хийж байсан, аймгийн Засаг дарга хийж байсан, эмнэлгийн дарга хийж байсан олон улсууд байж байна, хуулийнхан байж байна. Тэгэхээр танд асар их хүч байна. Хамтарч ажиллахгүй бол энэ салбарт маш чухал чухал салбарууд байгаа.

Ялангуяа эрүүл мэндийн салбарын асуудал байж байгаа. Эх, хүүхдийн эндэгдлийн асуудал, тэгээд хотын клиникийн эмнэлгүүдийн ачаалал, хөдөөгийн эмнэлгүүдийн ачаалал байж байна. Мөн оношилгооны асуудал байж байна, гадагшаа явж байгаа энэ иргэдийн асуудлууд байж байна, эмчилгээнд явж байгаа. Гэтэл эрүүл мэндийн салбар Эрүүл мэндийн даатгалын газар хооронд ерөөсөө гэрээ хийгдээгүйн улмаас тэгээд өчнөөн 100 мянган доллар төлөөд хохирч байгаа иргэд байж байна. Энэ урдаас бас ярьж байсан. Ер нь хамтраад ажиллахад энэ чухал асуудал маш их байгаа. Ялангуяа энэ оношилгооны тоног, төхөөрөмжийг, хотын эмнэлгүүдийн ачаалал.

Тэгээд эмнэлгийн салбарынхны цалин хөлс маш бага, тэгээд гадагшаа их явж байна. Хотын эмнэлгүүд чинь бүгд сувилалчийн дутагдалтай ерөөсөө. Эмч нар маш бага цалинтай, амьдрал нь хүрэлцэхгүй ийм асуудал байгаа. Энэ дээр бас анхаарах шаардлагатай.

Нөгөө талаар хавдрын өвчлөлийн асуудал байж байгаа. Хавдар маш их залуужиж байгаа, тэгээд ихсэж байна. Тийм учраас энэ эрүүл мэндийн салбарынхантайгаа, хотын клиник эмнэлгүүдтэй маш их хамтарч ажиллахгүй бол ерөөсөө энэ салбар цаашаа явахгүй. Зөвхөн намын чиглэлээр гэвэл энэ бүтэхгүй ээ, салбар болчихно.

Халамжийн асуудал байж байгаа юм. Маш эмзэг салбар, тахир дутуу иргэдийн асуудал байж байгаа. Хүүхэд хамгаалах, хүчирхийллийн асуудал байж байгаа. Мөн хөдөө сум, багийн эмийн сангийн хангалтын асуудал байж байгаа.

Хөнгөлөлттэй эм авч чадахгүй байна шүү дээ. Үүнийг ЭМЯ-тай хамтарч байж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарч байж энэ эм хангалтын асуудлыг нэг Эрүүл мэндийн сайд эрүүл мэндийн салбарынхантайгаа зөвшилцөж байж, сум, багийн түвшинд тэр хөнгөлөлттэй эмийг өгөх ямар арга байдаг юм, түүнийг эрүүл мэндийн салбарынхантай хамтраад шийдэхгүй бол, бас Засгийн газартай хамтраад шийдэхгүй бол шийдэх асуудал зөндөө байгаа.

Тэтгэвэр, тэтгэмжийн асуудал байж байна, түрүүн бас ярьсан.

Одоогийн нэг чухал асуудал Донорын тухай хуулийн асуудал байж байгаа. Эрхтэн солиулах тухай. Үүнийг бас оруулах тал дээр бас энэ салбарын яамнууд байж байна. Бусад асуудалтай хамтраад шийдэхгүй бол болохгүй.

Ноднин би Турк яваад Эх нялхсын төвд хүүхдийн элэг, бөөр шилжүүлж суулгах асуудлаар Монголд үнэгүй суурилуулах тал дээр энэ асуудлыг шийдээд ирсэн. Одоог хүртэл тэр салбар хөдлөхгүй байна. Үнэгүй байгуулж өгөөд байгаа шүү дээ, дэлхийн 17 дахь орон болоод манайд байгуулж өгөх гэж байгаа. Гэтэл үүний араас бас орохгүй байна, манайх.

Тэгэхээр ийм ийм асуудлууд дээр бас хамтарч ажиллаарай гэж хэлье.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Лутаагийн Энхнасанг Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар сонгохыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

Би дэмжсэн шүү, буруу гарчихлаа. Тийм 61 хувь нь дэмжсэн байна. 3 хүн байна уу энэ протоколд тусгаад авчих.

Тэгээд энэ хувийг нь нэмээд гаргачхаарай. 83-тай юм уу даа.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Лутаагийн Энхнасанг дэмжлээ.

Байнгын хорооны дарга Лутаагийн Энхнасан танд баяр хүргэж, ажилд нь амжилт хүсье.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Болормаа танилцуулна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан өндөрлөлөө.

Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

П.ОЮУНГЭРЭЛ